



БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ 10 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:


Монгол улсад орчин цагийн боловсролын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ой, Боловсролын газар байгуулагдсаны 30 жилийн ой, Монголын багш нарын баярын 55 дахь өдрийг тохиолдуулан боловсролын салбарын үүсэл, хөгжил, түүхэн замналыг иргэд, хүүхэд залуучуудад сурталчлах зорилгоор “Боловсрол-100” цахим үзэсгэлэнг 2021 оны 10 сарын 01-ний өдөр зохион байгуулсан.

Монголын багш нарын баяр” - ын өдөр, Боловсролын байгууллага үүсч хөгжсөний 100 жилийн ой, Багш нарын баярын өдөрт зориулсан баярын хурал, шагнал гардуулах ёслол, баярын тоглолтыг Боловсролын газрын пэйж хуудсаар дамжуулан шууд хүргэсэн. Шууд лайвыг 7858 хүн үзэж хандалт хийсэн.





2021 оны ЭЕШ-ын даалгаврын шинжлэгээг Шинжээч багш нартай хийн ЕБС –ын 12 дугаар ангид хичээл ордог багш нарт зөвлөмж хүргүүлээ.

Танхимын болон цахим хичээлийн үйл ажиллагаатай танилцах зорилгоор багш нарын цахим хичээлд суун зөвлөмж чиглэл хүргүүлж байна.



Цахим хаягаар дамжуулан Монгол бичгийн хичээл бэлтгэн иргэд олон нийтэд хүргэж ажиллаж байна. 10 дугаар сарын 20-ны байдлаар 3856 хүний хандалттай байна. Монгол бичиг суралцаж буй байгууллагын бичлэг хийн цахимд байршуулсан. Хэлний бодлого салбар зөвлөлийн төлөвлөгөөний дагуу монгол бичгийн гарын авлага бэлтгэн хэвлэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 25 дугаар зарлиг ёсоор жил бүрийн 9 дүгээр сарын 1 -ний өдөр уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлдэг "Эх хэлний өдөр" ийг тохиолдуулан цахим уралдаан явуулан шагнал гардуулав мөн аймгийн мэдээгээр мэдээлэл хүргэн Монгол бичиг сурах зөвлөмж хүргүүлэв.




“Зөвлөх багш”-ийн мэргэжлийн зэргийн шалгуурыг хангасан 6 багшийн холбогдох баримт, материалыг “Багшийн мэргэжил дээшлүүлэх институт”-д хүргүүлээ.

Англи хэлний Ментор багшийн сургалт хийн туршлага, арга зүйгээ хуваалцан харилцан мэдээлэл солилцов.



Өсвөр үеийн хүүхдүүдэд “Цахим хэрэглээний зөв хэрэглээ” болон “Үе тэнгийн дээрэлхэлт, дарамтыг илрүүлэх” сургалтыг 2021.10.15-17-ны хооронд цахимаар зохион байгууллаа. Сургалтыг хамтран Монголын сэтгэл заслын холбооны сэтгэл зүйч Б.Алтантуяа, хүүхэд хамгааллын мэргэжилтэн Б.Уранзаяа нар сургалтандын хүрээнд: Үе тэнгийн дээрэлхэлт, дарамт талаарх ойлголт, мөн чанар, хэрхэн таслан зогсоох, хэрхэн урьдчилан сэргийлэх, хэрхэн мэдээлэх, тусламж хүсэх, чиний оролцоо гэсэн агуулгын хүрээнд зохион байгууллаа. Сургалтанд 6-10 дугаар ангийн нийт 315 суралцагчид хамрагдсан.




Сургуулийн өмнөх боловсрол

Төрийн 4 цэцэрлэг, хувийн 1 цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаатай танилцан хяналт тавин зөвлөмж, зөвлөгөө өгч ажилласан. Цэцэрлэгийн 4-5 багшийн хичээлд цахим хичээлд суун зөвлөмж чиглэл өгч ажиллалаа. Мөн коронавирус цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмийг хэрхэн дагаж мөрдөж ажиллах талаар зөвлөмж чиглэл өгсөн.

“Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ”-г Шивээговь сумын сургуулийн 1-р ангид суралцаж байгаа 43 хүүхдэд хийн ажилласан. Сургууль 1-р ангийн багш, цэцэрлэгийн 5 настай хүүхэдтэй ажилладаг нийт 20 багшид “Сургууль бэлтгэгдсэн байдлыг үнэлэх арга зүй” сургалтын арга зүй хэрхэн бэлтгэх талаар сургалтыг зохион байгуулсан.

ХБХ-ын талаархи тайланг сургууль, цэцэрлэгээс хүлээн авч хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаж байна. Сургууль, цэцэрлэг бүр ХБХ-ын төсвийг ДЗОУБ-тай хамтран хэрэгжүүлэн ажиллаж байна. Сургуулийн менежерүүдтэй “Тэгш хүртээмжтэй боловсрол ба түүний эргэн тойронд” сургалтад хамрагдсан.

“Ахмадын зөвлөн туслах” ажлыг 3 ахмад багш хийхээр төлөвлөгөө гарган, гэрээг байгуулсан зөвлөн туслах ажлыг зохион байгуулж байна.



СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төвөөс "Соёлын биет бус өвийг бүртгэн баримтжуулах нь" цахим программын сургалтыг 2021 оны 10 сарын 18ны өдөр

зохион байгууллагдаж БСУГ-ын мэргэжилтэн, Музейн бүртгэл мэдээллийн санч нар хамрагдсан.

Энэхүү программ 11 сард хэрэглээнд нэвтрэх бөгөөд Соёлын биет бус өв түүнийг өвлөн уламжлагчийг бүртгэх бүртгэлийн программд анхан шатны байдлаар бүртгэгдсэн 21 аймаг 9 дүүргийн 10849 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нарын мэдээлэл цахимд шилжих юм.

Манай аймгийн хувьд 320 өвлөн уламжлагчдын мэдээлэл орсон бөгөөд 225 өвлөн уламжлагчдын мэдээлэлд засвар хийгдэнэ.

Соёл урлагийн их сургууль нь соёл, урлагийн сургалт-судалгаа-инноавцийн үйл ажиллагааг дагнан хэрэгжүүлдэг их сургуулийн хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд манай аймгийн түүх, соёлын өвийг судлах, соёлын бүтээлч үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хөгжүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах, хүүхэд, залуучуудад үндэсний үнэт зүйлийг ухамсарлуулах, түүх, соёлоороо бахархах ёс зүйтэй иргэн болгон төлөвшүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах чиглэлээр уулзалтыг цахимаар зохион байгууллаа. Сургалтанд СУБ-ын удирдлагууд, НБХ-ийн дарга, мэргэжилтэн,

Сүмбэр сумын 2-р багийн иргэн М.Чинбатын гар дээр хадгалагдаж буй 10 нэр төрлийн 54 эд өлгийн зүйлсээр музейн үзэсгэлэнгийн танхимд “Миний цуглуулга – ХХ зуун” сэдэвт үзэсгэлэнг цахимд байршуулан 492 хүн хандаж 165 хүн хариу үйлдэл үзүүлж, 165 хүнд иргэдийн гар дээр хадгалагдаж буй эд өлгийн зүйлсийг хүргэж мэдлэг олгосон.

Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Аймгийн ЗДТГазартай хамтран АЙМГИЙН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧДЫН 2-Р ЗӨВЛӨГӨӨН-ийг танхим болон цахимаар хослуулан халдвар хамгааллын дэглэмийг баримтлан зохион байгууллаа. Зөвлөгөөнд оролцсон өвлөн уламжлагчдаас Говьсүмбэрийн төлөө медаль- Г.Арилд, Г.Цэгмэд, ХАА-н тэргүүний ажилтан Хонин сүрэг маллах арга ухаан Б.Дуламжав, Аймгийн засаг даргын өргөмжлөл, 100.000 төгрөгөөр Ж.Сүнжидмаа, Д.Самданбазар, З.Бадамсүрэн, Б.Цэрэндаш, Ш.Баярмаа, Д.Нараа, Ц.Хатанбаатар, Б.Оюунчимэг нарыг 8-н өвлөн уламжлагч шагнаж урамшуулсан.



Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч нарын олон нийтэд сурталчдан таниулах, алдаршуулах зорилгоор Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд ай савын Монгол уран бичлэг өвийг өвлөн уламжлагч Э.Олонцэцэг, М.Алимаа, Ардын язгуур урлагт бүртгэлтэй Д.Нараа, Л.Түмэнцэцэг, Т.Болдбаатар, Д.Должинсүрэн, Ж.Сүнжидмаа

нарыг Цахимд байршуулан алдаршуулсанаар 2066 хүн хандаж, 1307 иргэн хариу үйлдэл үзүүлж өвлөн уламжлагчдаа алдаршуулах ажлыг зохион байгуулсан.


Сүмбэр сумын Лүнгийн хадат гэх газар шинээр дугуй булш-14, дөрвөлжин булш-3, хэлбэр алдагдсан 2. Нийт 19 дурсгал шинээр олж илрүүлэн бүртгэн баримтжуулсан. Боржигин өв музейн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй 22 газрын 253 дурсгалын 4 цэгийн координат тогтоож, талбайн хэмжээ тогтоох судалгааны ажил хийсэн.

“Уул овоо таних зан үйл, газар нутгийн нэршил” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт сүмбэр сумын 4,5,6-р багийн дарга, БСУГазрын соёлын мэргэжилтэн, НБХэлтсийн мэргэжилтэн, Шивээговь сумын соёлын төв, баянтал сумын соёлын төв,ГХБХБГазрын мэргэжилтэн, Орон нутгийн судлаач, Музейн албан хаагч, Иргэдийн төлөөлөл, багийн засаг дарга нийт 15 хүн оролцож санал солилцон газрын нэршлийг ГХБХБГазрын 1960 оны нэршилтэй тулган үзэж, судалгаа хийсний үр дүнд нэршлийг тогтоож байхаар шийдвэрлэсэн.

Соёлын төвийн стандарт, үлгэрчилсэн журмын төсөлд саналыг гарган хүргүүлсэн.

Удирдлагын академиас зохион байгуулж буй төрийн жинхэнэ албан хаагчдыг мэргэжшүүлэх дунд хугацааны сургалтанд хамрагдаж мэргэжил боловсролоо дээшлүүлж байна.

ТАЙЛАНГ НЭГТЭСЭН:
БСУГ-ЫН БИЧИГ ХЭРЭГ:



Л.ЭНХЧИМЭГ